# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 29 өдөр Дугаар А/44 Арвайхээр

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай тухай 29 дүгээр зүйлийн 29.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 16 дугаар зүйлийн 16.2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 07/05 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2020 оны А/589 дүгээр захирамжаар олгогдсон Согтууруулах ундаа худалдах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй Бат-Өлзий сумын 5 дугаар багт үйл ажиллагаа явуулж буй Н.Болдбат эзэмшигчтэй “Мөнххайрхан” хүнсний дэлгүүрийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэрийг өөрийн хүсэлтийн дагуу өөрчилж “ЖСБ” ХХК-ний (РД:3567958) “Мөнххайрхан” хүнсний дэлгүүрт тусгай зөвшөөрлийн өөрчлөлтийг хийж олгосугай.

2.Тусгай зөвшөөрлийн эзэмшигчийн нэр өөрчилсөнтэй холбогдуулан тухайн аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрлийг шинээр хэвлэн, баталгаажуулж олгох, хяналт тавьж ажиллахыг (А.Отгонцэцэг)-д даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/589 дүгээр захирамжийн Н.Болдбаттай холбогдох заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА А.ИШДОРЖ

011100100

D:My Doc. Zahiramj. Zasag darga